| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,814,979,600.00 | 2,793,524,951.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,814,979,600.00 | 2,793,524,951.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,809,359,600.00 | 2,788,264,951.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,379,385,000.00 | 2,378,840,418.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,310,003,400.00 | 1,310,003,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,033,524,100.00 | 1,032,979,518.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,857,500.00 | 35,857,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,092,600.00 | 51,003,857.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 51,092,600.00 | 51,003,857.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 102,415,600.00 | 100,031,860.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,771,000.00 | 19,387,260.00 |
| 210302 | Түлш, халаалт | 75,421,700.00 | 75,421,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,222,900.00 | 5,222,900.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 149,616,400.00 | 148,180,048.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,718,000.00 | 19,718,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 113,425,400.00 | 113,425,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,393,000.00 | 10,956,648.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 23,875,000.00 | 23,875,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,075,000.00 | 22,075,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,220,000.00 | 72,220,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,380,000.00 | 5,380,000.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 62,840,000.00 | 62,840,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,740,000.00 | 9,614,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,740,000.00 | 9,614,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,515,000.00 | 2,007,668.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,404,000.00 | 907,668.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 561,000.00 | 550,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | 550,000.00 | 550,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,500,000.00 | 2,491,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 2,491,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,620,000.00 | 5,260,000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,620,000.00 | 5,260,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 140,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,120,000.00 | 5,120,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,814,979,600.00 | 2,793,524,951.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,757,653,600.00 | 2,721,360,372.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,757,653,600.00 | 2,721,360,372.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 57,326,000.00 | 72,164,579.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 57,326,000.00 | 72,164,579.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 0.01 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 158.00 | 158.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 3.00 | 3.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 147.00 | 147.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **158.00** | **158.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 150.00 | 150.00 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |

| | | | |
|---|---|---|---|
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4.00 | 4.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **68,517,350.00** | **120,626,430.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **68,517,350.00** | **120,626,430.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 68,517,350.00 | 120,626,430.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,590,930.00 | 1,467,204.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 613,930.00 | 1,467,204.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,977,000.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,480,868.00 | 27,401,398.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 219,000.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,354,900.00 | 22,341,530.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,906,968.00 | 4,906,968.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 152,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,957,850.00 | 1,825,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 15,957,850.00 | 1,825,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,352,702.00 | 25,900,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 20,000,000.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,873,600.00 | 4,360,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,479,102.00 | 1,540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,525,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,525,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,610,000.00 | 64,032,828.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 58,652,828.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,610,000.00 | 5,380,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 68,517,350.00 | 120,626,430.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 68,517,350.00 | 120,626,430.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,000,000.00 | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,228,200.00 | 46,961,950.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 52,289,150.00 | 73,664,480.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 28/420 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн тусгай алба байна.

Тайлант онд удирдлагын манлайлал, алба хаагчдын сахилга, хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь ЦЕГ, түүний харъяа төв орон нутгийн салбар нэгжүүдэд хүрч ажилладаг. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдалтай холбоотой хараат бус байдлыг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна.

Тус аймаг дахь Цагдаагийн газарт 2021 онд Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 3131.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 31.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 25.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137.9 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 229.2 | 202.8 | -26.4 |
| Үндсэн хөрөнгө | 3018.4 | 2906.9 | -111.5 |
| **Нийт хөрөнгө** | **3247.6** | **3109.7** | **-137.9** |
| Өр төлбөр | - | - | |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3247.6 | 3109.7 | -137.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3247.6** | **3109.7** | **-137.9** |

Мөнгөн хөрөнгө данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлаас 21.5 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 14.8 сая төгрөгийн, нийт 36.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 202.8 сая төгрөг болж 26.4 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй он удаан жил болсон бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл тусгай зориулалтын материалын үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 7.3 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад бараа материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс буурсан дүнтэй байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 284.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, ЦЕГ-аас үнэ төлбөргүй олгосон 9.6 сая төгрөгийн бараа материал, 1.6 сая төгрөгийн шатахууны урамшуулалыг бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 111.5 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: тайлант онд төсвийн хөрөнгөөр 49.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч , ЦЕГ-аас 54.5 сая төгрөгийн, орон нутгийн төсөвт байгууллагуудаас аймгийн ИТХ-ын шийдвэрээр 30.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авчээ. Тайлант онд 9.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тээврийн хэрэгслийг акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөд нийт 245.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд үйл ажиллагаатай холбоотой өр үүсгээгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 137.9 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд 138.7 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ.

Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3046.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 171.2  сая төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн  байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 167.7 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлого 1.7 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 52.1 сая төгрөгөөр тус тус өссөн дүнтэй байна.

Нийт зардал 3185.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 17.7 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хангамж бараа материалын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 138.7 сая төгрөг байна. Өмнөх оны үр дүнд 0.8 сая төгрөгийн залруулга хийсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагдаагийн ерөнхий газраас тус газрын анхны төсвийг 2779.5 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 2814.9 сая төгрөг болгон өөрчилж, анх баталснаас 35.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 38 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2814.9 сая төгрөгийн төсөв баталснаас 2757.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 57.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2757.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2793.5 сая төгрөгийг зарцуулжээ. Үндсэн үйл ажиллагааны орлогоос 57.3 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 72.2 сая төгрөгийг оруулж, давсан 14.8 сая төгрөгийн орлогыг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн санхүүжилтээс 21.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд: нэмэгдэл цалингийн зардлаас 0.5 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын зардлаас 0.1 сая төгрөгийн, гэрэл цахилгааны зардлаас 2.3 сая төгрөгийг, шуудан холбооны зардлаас 1.5 сая төгрөгийг, дотоод томилолтын зардлаас 11.1 сая төгрөгийг, тээврийн хэрэгслийн татвараас 0.5 сая төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлаас 0.4 сая төгрөгийг, бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 5.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2793.5 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь тайлант оны батлагдсан төсвөөс цалингийн нэмэгдэл, урамшуулалт цалинг 0.5 сая, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 0.1 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.4 сая, хангамж бараа материалын зардлыг 1.4 сая, томилолтын зардлыг 11.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 5.5 сая, урсгал шилжүүлгийн зардал 0.4 сая, нийт 21.4 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс 120.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: гэрэл цахилгааны зардалд 1.5 сая, хангамж, бараа материалын зардалд 27.4 сая, нормативт зардалд 1.8 сая, эд хогшил худалдан авах зардалд 25.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 64.0 сая, нийт 120.6 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цагдаагийн газар нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2599.6 сая төгрөгийн 108 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн дансанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 482.4 сая төгрөгийн 9 гүйлгээг байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 92.4 хувьтай байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны орлогыг илүү тайлагнасан, ажилчдад олгосон урьдчилгааг суутгаж аваагүй зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг хугацаанд ирүүлсэн, тайлант онд зөрчлийг арилгаж, давтан гаргаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх эсвэл анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, зөрчил илэрч зөвлөмж өгөгдлөө.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

*1.Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах ёстой мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг хугацаанд бүрэн байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Цагдаагийн газар | | | | | | | | | 1 | - |